



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН
ТУШААЛ**

2010 оны 11 сарын 10 өдөр

Дугаар 107

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 123, 124, 125 дугаар зүйл, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2009 оны 198 тоот тушаалаар баталсан “Ялтныг нийгэмшүүлэх ажлын хөтөлбөр”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын зөвлөлийн 2010 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтнуудын өдөр тутмын үйл ажиллагаанд энэхүү зааврыг мөрдлөг болгон ажиллуулахыг хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны дарга нарт үүрэг болгосугай.

3. Зааврын хэрэгжилтэнд хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар ханган үр дүнг тооцож ажиллахыг Тогтоол гүйцэтгэх газар /хурандаа Д.Даваа-Очир/-т даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2008 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/132, 2009 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн А/23 тоот тушаалуудыг тус тус хүчингүйд тооцсугай.

ДАРГА, ХУРАНДАА

М.ГАНХҮҮ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын
даргын 2010 оны А/107 дугаар тушаалын
хавсралт

ХОРИХ АНГИ, ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ НИЙГМИЙН АЖИЛТНЫ АЖЛЫН ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү зааврын зорилго нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд ял эдэлж байгаа ялтан болон цагдан хоригдож байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч /цаашид хоригдогч гэх/-д нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг тодорхой түвшинд хүргэх замаар хоригдогч нийгэмших, тэдгээрт нийгэм, сэтгэл зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгоход оршино.

1.2 Энэ заавраар хоригдогчийг нийгэмшүүлэх ажил, тэдгээртэй ажиллах нийгмийн ажилтны үйл ажиллагааны явцад үүсч буй харилцааг зохицуулна.

1.3. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажил нь хоригдогчийг нийгэмшүүлэхэд чиглэгдсэн нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх, хоригдогчийн нийгмийн харилцаанд тодорхой үүрэг, байр суурьтай оролцох чадварыг хөгжүүлэхийн зэрэгцээ, нийгэм, сэтгэл зүйн хувьд тогтвортой байлгах, хувь хүнийг төлөвшүүлэхэд туслалцаа, дэмжлэг үзүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа юм.

1.4. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтан нь мэргэжлийн хувьд нийгмийн ажлын боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй эсхүл нийгмийн ажлын чиглэлээр мэргэжлийн болон давтан сургалтанд хамрагдан мэргэшсэн цэргийн албан хаагч байна.

1.5. Хорих, анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтан нь Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол улсын хууль, Монгол улсын нэгдэн орсон Олон улсын Хүний эрхийн тухай эрх зүйн бичиг баримтууд, Нийгмийн ажилтны ёс зүйн дүрмийг мөрдлөг болгон ажиллана.

1.6. Нийгмийн ажилтан нь хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны дарга, дэд даргын шууд удирдлаган дор ажиллана.

1.7. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд хоригдогчийг чадваржуулах, сэтгэл зүйн хувьд тогтвортой байлган нөхөн сэргээх, нийгэмшүүлэх үйлчилгээг үзүүлэхэд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нараас бүрдсэн баг ажиллуулах ба мэргэжлийн бие даасан үйл ажиллагаатай байхаар зохион байгуулна.

1.8. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны ахлах нийгмийн ажилтан болон нийгмийн ажилтныг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх орон тооны бус салбар зөвлөлийн хуралдааны шийдвэр болон мэргэжлийн үйл ажиллагаанд гарсан бодит ахиц өөрчлөлт, үр дүнд өгсөн санал дүгнэлтийг үндэслэн хууль тогтоомжинд заасан шагналаар урамшуулна.

Хоёр. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд явуулах нийгмийн ажлын зохион байгуулалт

2.1. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтан нь төрийн ба төрийн бус болон шашны байгууллага, иргэд, ар гэрийн дэмжлэг туслалцааг авна.

2.2. Хоригдогчийг зөв зан үйлд хэвшүүлэн сургаж төлөвшүүлэхэд хорих байгууллагын албан хаагчдыг татан оролцуулж, ялтны өөрийгөө чадавхижуулах багийг идэвхжүүлэн хамтран ажиллана.

2.3. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд явуулж буй нийгмийн ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, нийгэмшүүлэх ажлын явцыг хянах, үр дүнг тооцох үйл ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тогтоол гүйцэтгэх газрын Ялтны сургалт хүмүүжлийн хэлтсээс зохион байгуулна.

2.4. Нийгмийн ажлын албаны тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор батлагдсан загвар үзүүлэлтийн дагуу Тогтоол гүйцэтгэх газрын Ялтны сургалт, хүмүүжлийн хэлтэст ирүүлж байна.

2.5. Тогтоол гүйцэтгэх газрын Ялтны сургалт хүмүүжлийн хэлтсээс хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны тайланг нэгтгэн дүгнэж, цаашдын үйл ажиллагааны чиглэлээр үүрэг чиглэл, зөвлөмжийг өгч ажиллана.

2.6. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны үйл ажиллагааг дэмжих зорилт бүхий мэргэжлийн удирдлагаар хангах, мэргэжлийн сургалт зохион байгуулах ажлыг ШШГЕГ-ын дэргэдэх орон тооны бус салбар зөвлөл зохион байгуулж ажиллана.

2.7. Тогтоол гүйцэтгэх газрын Ялтны сургалт, хүмүүжлийн хэлтэс нь хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарт зориулсан цахим мэдээллийн сантай байна.

2.8. Цахим мэдээллийн санд хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарт зориулсан мэдээ мэдээлэл, мэргэжлийн заавар зөвлөгөө, хууль, журам, нэвтрүүлэх тэргүүн туршлага, судалгаа шинжилгээний баримт бичиг зэргийг байршуулна.

2.9. Цахим мэдээллийн сан нь нээлттэй хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулах ба шаардлагатай асуудлаар иргэд байгууллагаас санал хүсэлт хүлээн авч ажиллах боломжтой байна.

Гурав. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба дахь нийгмийн ажилтны явуулах судалгаа

3.1. Шинээр ирсэн хоригдогчийг дараах чиглэлээр судлана:

- 3.1.1. зан төлөв,
- 3.1.2. биеэ авч яваа байдал,
- 3.1.3. хувийн сэтгэл зүйн онцлог,
- 3.1.4. орчны өөрчлөлтөөс шалтгаалан сэтгэл санааны хямралд орсон эсэх,
- 3.1.5. хувь хүний давуу талууд буюу мэргэжил, боловсрол, спорт, урлагын болон бусад авьяас чадвар, боломжууд,
- 3.1.6. ар гэр, төрөл төрөгсөд, найз нөхөд буюу ойр дотны хүмүүсийн талаар,
- 3.1.7. ажиллаж, амьдарч байсан газар, нутаг орон,
- 3.1.8. урьд нь ял шийтгэл эдэлж байсан тохиолдолд тухайн үеийн ял эдлэлтийн байдал,
- 3.1.9. үйлдсэн гэмт хэргийн байдал.
- 3.1.10. сэтгэцийн эрүүл мэндийн байдал.

3.2. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтан нь дээрхи чиглэлээр судалгаа хийхдээ ажиглалт хийх, шат дараалсан ярилцлага явуулах, хувийн баримт бичигт дүгнэлт хийх болон шинжлэх ухааны бусад аргаар судлана.

3.3. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтан нь хийгдсэн судалгаанд үндэслэн дараах шийдвэрийг гаргана:

- а/ цаашид нийгэмшүүлэх чиглэлээр ямар үйл ажиллагаа явуулахаа тодорхойлох,
- б/ тухайн хоригдогчтой ажиллах арга, аргачлалаа тогтоох,
- в/ байгууллагын зүгээс хоригдогчийн талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд мэргэжлийн зөвлөмж өгөх.

3.4. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтан нь хоригдогчийн нийгэм сэтгэлзүй, зан байдлын онцлог, төлөвшилтийг тодорхойлох судалгааг явуулахдаа дангаар эсхүл хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны бусад албад болон мэргэжлийн байгууллагатай хамтран явуулна.

Дөрөв. Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үндсэн үйлчилгээ.

4.1. Хоригдогчийн нийгмийн болоод сэтгэл зүйн хэрэгцээнд үндэслэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох.

4.2. Хоригдогчид ял эдлэх болон хоригдох явцад тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх.

4.3 Хоригдогчийн хувийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, тэдгээрийг чадваржуулах, хувь хүний давуу тал, нөөц боломжийг нээн хөгжүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.

4.4. Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын нөлөөлөл үзүүлэх.

4.5. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд хэрэгжүүлэх нийгмийн ажилд хоригдогчийн өөрийгөө чадавхижуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах,

4.6. Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах;

4.7. Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэлзүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх.

Тав. Нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагаа

5.1. Хоригдогчид чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох

5.1.1. Шүүхийн шийдвэрээр хүргэгдэн ирсэн хоригдогчийг хүлээн авсны дараа 7 хоногийн хугацаанд хоригдогчийн хувийн хэрэг, иргэний бичиг баримт бусад мэдээллийг цуглуулан энэ журмын 3 дугаар зүйлийн 3.1 –т заасан судалгааг явуулна.

5.1.2. Хоригдогч нэг бүрийн сэтгэлзүйн хэрэгцээ, хувь хүний эерэг болон сул тал, нийгмийн харилцааны асуудал, бэрхшээлийг нь илрүүлж, үнэлгээ өгч ганцаарчилсан болон бүлгээр ажиллах чиглэлийг тодорхойлох.

5.1.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар, бусад зайлшгүй анхаарах, мэдвэл зохих асуудлын талаар хоригдогчид танилцуулж анхан шатны мэдлэг олгох, нийгмийн ажилтны чиг үүргийг танилцуулах.

5.1.4. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтан нь энэ зааврын гуравдугаар бүлэгт заасан судалгаа болон хоригдогчдыг нийгэмшүүлэх хөтөлбөр, энэ зааврыг үндэслэн тэдгээрийг хэрэгжүүлэх зорилгоор сар, улирал, жилийн нийгэмшүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан байгууллагын даргаар батлуулан хэрэгжүүлж ажиллана.

5.1.5. Хоригдогчийг нийгэмшүүлэх ажлын төлөвлөгөөнд дараах зүйлсийг тусгана:

а\ хоригдогчийн нийгэм сэтгэлзүй, зан байдлын онцлог, төлөвшилтийг тодорхойлох судалгааг явуулах аргачлал, хугацаа,

б\ хоригдогчтой харилцаа, холбоо тогтоох үйл ажиллагаа,

в\ хоригдогчийн онцлогт тохируулан явуулах нийгэмшүүлэх ажлын төрөл, хугацаа, хүрэх үр дүн,

г\ төрийн, төрийн бус байгууллага хамтран хэрэгжүүлэх ажлын талаар,

д\ бусад шаардлагатай ажлууд,

5.1.6. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтан нь хоригдогчийг нийгэмшүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт, судалгааг энэ зааврын 2 дугаар зүйлийн 2.4-т заасны дагуу шийдвэрлэнэ.

5.2. Хоригдогчид тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа.

5.2.1.Хоригдогчийн зан төлөв, сэтгэлзүйн хандлагыг судалж, бодитоор тогтоох зорилгоор хорих ангийн сэтгэлзүйчтэй хамтран судалгааны ажлыг тогтмол явуулна.

5.2.2.Анх удаа болон шинээр ирсэн хоригдогчдын дундаас орчны өөрчлөлтөөс шалтгаалан сэтгэлзүйн гүнзгий хямрал, өөрчлөлтөд орсон хоригдогчтой ганцаарчлан ажиллаж, эрх зүйн болон нийгмийн ажлын зөвлөгөө туслалцааг үзүүлнэ.

5.2.3.Шашны болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хамтран хоригдогчдийн таагүй орчин нөхцлөөс үүдэн гарах хууль бус үйлдээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөгөө өгч хамтран ажиллана.

5.2.4.Хоригдогчийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль эрх зүйн болон амьдрах нөхцлийн талаар таниулан ойлгуулах уулзалт, ярилцлага болон бусад арга хэмжээг зохион байгуулна.

5.2.5.Хоригдогчийн дунд амиа хорлох явдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр бусад албатай хамтран зохих ажлыг явуулна.

5.2.6.Нийгмийн ажилтан нь хоригдогчийг хууль эрх зүй, танин мэдэхүй, мэдээллийн гарын авлага, зөвлөмжөөр хангаж, зан байдлын сөрөг өөрчлөлтөнд орохоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.

5.3 Хоригдогчийг чадваржуулах чиглэлээр сургалт зохион байгуулах ажиллагаа.

5.3.1.Хоригдогчид суурь боловсрол олгох болон амьдрах ухааны сургалтуудыг мэргэжлийн байгууллага, сургууль, хувь хүнтэй хамтран зохион байгуулна.

5.3.2.Сургалтын төлөвлөгөө боловсруулах, сургалтыг зохион байгуулахад хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны үйлдвэрлэлийн чиглэл, дотоод онцлог нөхцөл байдлыг харгалзан үзнэ.

5.3.3.Хоригдогчоос болон өөрийгөө чадавхижуулах багаас сургалтын ажлын хэрэгцээ шаардлагын талаарх судалгаа, санал асуулгыг авч сургалтын ажлын төлөвлөгөөнд тусган ажиллана.

5.3.4.Мэргэжил эзэмшүүлэх, хөдөлмөрийн дадал олгох сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран хоригдогчдод мэргэжил эзэмшүүлж мэргэжлийн үнэмлэх буюу чадамжын гэрчилгээг олгуулах ажлыг зохион байгуулна.

5.3.5.Мэргэжлийн үнэмлэх буюу чадамжын гэрчилгээ нь хорих ял эдэлж байгаа болон суллагдсан иргэн цаашид уг мэргэжлээр ажил, үйлчилгээ эрхлэх бололцоог нээсэн буюу холбогдох хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөгдөж баталгаажсан байна.

5.3.6. Нийгмийн эрүүл мэндийн эсрэг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор хамтран зохион байгуулна.

5.3.7.Тусгай бэлтгэсэн хөтөлбөрийн хүрээнд хэвлэл, мэдээллийн хэрэгсэл /радио, телевиз, сонин хэвлэл/ ашиглан төрөл бүрийн хэлбэрээр зайны сургалт явуулж болно.

5.3.8.Хоригдогчийг чадваржуулах, мэргэшүүлэх сургалтанд дараах техник хэрэгслээс ашиглаж ажиллана. Үүнд:

- а.радио
- б.телевизор
- в.дүрс, дуу бичлэгийн магнитофон, хуурцаг
- г.ном, сонин сэтгүүл, гарын авлага, кино, бусад материал /мэргэжлийн холбогдолтой/
- д.видео проектор, кадоскоп
- е.компьютер

5.3.9. Хоригдогчийн их, дээд сургууль, коллежид бие даан үргэжлүүлэн суралцаж боловсролоо дээшлүүлэхэд суралцах орчин нөхцлийг бүрдүүлэхэд туслалцаа үзүүлэх ажлыг төрийн захиргааны болон мэргэжлийн сургууль, байгууллагатай хамтран зайны, албан бус сургалтыг зохион явуулж болно.

5.3.10. Хоригдогчийн их, дээд сургууль, коллежид бие даан суралцах боловсролын зэргээ дээшлүүлэхтэй холбогдох зардлыг суралцагч буюу ар гэр нь бүрэн хариуцах ба төрийн бус байгууллагын хандив туслалцаа авч болно.

5.3.11. Хоригдогч гадаад хэлийг сонгон судалж, суралцахад хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны зүгээс дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн байгууллагатай хамтран гэрчилгээ олгох ажлыг нийгмийн ажилтан зохион байгуулна.

5.3.12. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба нь хоригдогчийн сургалтанд зориулагдсан онолын болон, дадлагын танхимтай байна. Дадлагын танхим нь төрөлжүүлсэн мэргэжлийг эзэмшүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

5.4. Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын үйл ажиллагаа

5.4.1.Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд нийгмийн ажлын болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, хууль зүйн зөвлөгөө өгөх өрөө, танхимыг байгуулах ба энэ ажлыг хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны удирдлага хариуцан зохион байгуулна.

5.4.2.Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд уламжлалт шашны зан үйл үйлдэх “Зан үйлийн өргөө”-г байгуулан ажиллана. “Зан үйлийн өргөө”-гөөр дамжуулан хоригдогсдод нийгмийн ажлын дэмжлэг тусалцаа үзүүлэх ажлыг нийгмийн ажилтан, сэтгэлзүйч, шашны төлөөлөгчтэй хамтран зохион байгуулна.

5.4.3.Нийгмийн ажилтан нь тухайн хоригдогчийн намтрын судалгаан дээр тулгуурлан нийгмийн ажлын нөлөөллийн хэлбэрийг сонгон хэрэгжүүлнэ.

5.4.4.Нийгмийн ажилтан нь сэтгэл зүйчтэй хамтран хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөх нөлөөллийн болон сэтгэлзүйн, сэтгэл заслын мэргэжлийн үйлчилгээг үзүүлнэ.

5.4.5.Сэтгэл зүйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх ажиллагааг тусгайлсан эрх зүйн бичиг баримтаар зохицуулна.

5.4.6.Хар тамхи, мансууруулах бодис, бусад аргаар донтох явдлаас урьдчилан сэргийлэх, түүний хор хөнөөл, үр дагаварыг таниулах ажлыг тогтмол зохион байгуулна.

5.5. Нийгмийн ажлын үйл ажиллагаанд хоригдогчийн өөрийгөө чадавхижуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах,

5.5.1. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилд хоригдогчийг гэмт болон сөрөг зан үйлд уриалсан эсхүл хорих байгууллагын аюулгүй байдалд хор учруулахад чиглэгдсэн утга агуулаагүй хоригдогчийн өөрийгөө чадавхижуулах баг, олон улсын болон олон нийтийн байгууллагыг татан оролцуулах ажлыг тогтмол, нээлттэй явуулна.

5.5.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хоригдогчийн авьяас, чадварыг нээн хөгжүүлэх болон бусад нийгмийн ажлын үйл ажиллагааг нийгмийн ажилтан нь дангаар буюу төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж ажиллана.

5.5.3. Гэмт хэргийн хор уршгийг таниулах, нийгэмд учруулсан хохирлоо нөхөн төлөх, үйлдсэн гэмээ ойлгож ухамсарлах боломжийг олгох ажилд хоригдогчийн өөрийгөө чадавхижуулах баг, төрийн бус байгууллагыг оролцуулж, энэ ажлын үр дүнгийн талаар улирал бүр нийт хоригдогчидод мэдээлэл хийнэ.

5.5.4. Хоригдогчийн өөрийгөө чадавхижуулах багийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгцээ шаардлага, хэлбэрийг тодорхойлоход нийгмийн ажилтны зүгээс дэмжлэг тусалцаа үзүүлж ажиллана.

5.5.5. Хоригдогчийн дунд сөрөг зан байдлаа засах, архи, согтууруулах ундаа, мансуурлах бодис хэрэглэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн, бүлгийн ажлыг, сургалт, ярилцлагын хэлбэрээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран сар бүр зохион явуулна.

5.5.6. Хоригдогчийг нийгмийн сайн дурын ажилд өөрийн хүсэлтийг харгалзан татан оролцуулж болно.

5.5.7. Хоригдогч болон тэдгээрийн гэр бүлийг хамарсан уулзалт, нээлттэй өдөрлөг зохион байгуулна. Энэ ажлын хүрээнд хоригдогчийн гэр бүлд чиглэсэн ажлыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулна.

5.5.8. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтан нь мэргэжлийн байгууллагатай хамтран хоригдогчийн урлаг, спортын болон бусад авьяас, чадварыг олон нийтэд сурталчилах арга хэмжээг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.

5.5.9. Хоригдогчийн авьяас чадвар, хүсэл сонирхол дэмжин хөгжүүлэх ажлыг хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны удирдлага нийгмийн ажилтантай хамтран зохион байгуулна.

5.6. Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах ажиллагаа

5.6.1. Бие даан мэдлэг боловсролоо дээшлүүлэх тухай хоригдогчийн хүсэлтийг харгалзан тэдэнд бүх талын дэмжлэг үзүүлэхэд зуучлана.

5.6.2. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба өөрийн номын санг дотоод журамд нийцүүлэн тэдэнд эерэг нөлөөг үзүүлэхүйц ном, хэрэгслээр номын санг баяжуулна.

5.6.3. Хоригдогчийн эзэмшсэн мэргэжил дадлагыг харгалзан тэднийг ажлын байраар хангах боломжийг судлан шийдвэрлүүлнэ.

5.6.4. Хоригдогчийн хүсэл, сонирхлыг харгалзан ардын уламжлал, шашны зан үйлд оролцох боломжийг хангана.

5.6.5. Хоригдогчийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.

5.6.6. Хоригдогчийг шаардлагатай мэдээллээр хангахын зэрэгцээ хоригдогчид зориулсан хууль эрх зүй, танин мэдэхүйн гарын авлага, зөвлөмжийг боловсруулан түгээх буюу сурталчлах ажлыг хэрэгжүүлнэ.

5.6.7. Хоригдогчоос гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг нийгмийн ажилтан хүлээн авч судлан саналаа хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны удирдлага, бусад албан тушаалтанд хандан шийдвэрлүүлнэ.

5.6.8. Хоригдогч нь ял эдлэж байх үедээ дэвшилтэт шинэ технологи, шинжлэх ухаан техникийн ололт, эдийн засгийн үр ашиг өгөхүйц, хөдөлмөр хөнгөвчилсөн бүтээл туурвисан гэж үзвэл уг бүтээлийг эзэмшигчээр баталгаажуулж тогтоолгохоор тодорхойлолт гарган шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулна.

5.6.9. Хоригдогчийн хууль, тогтоомжоор хориглоогүй зарим эрх буюу иргэний эрх зүйн харилцаанд оролцох боломжоор хангаж өгөх ажлыг нийгмийн ажилтан хариуцан зохион байгуулна.

5.7. Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх ажиллагаа

5.7.1. Ялын хугацаа дуусч, суллагдах хугацаа ойртож буй хоригдогчыг нийгмийн амьдралд гарахад бэлтгэх ажлыг дараахь үндсэн хэлбэрээр зохион байгуулна. Үүнд:

а\ Нийгмийн амьдралын талаарх мэдээллээр хангах;

б\ Суллагдсаны дараа сэтгэлзүйн хувьд учирч болох саад бэрхшээл, эрсдлийг даван туулах чадвар эзэмшүүлэх;

в\ Бичиг баримтжуулах;

г\ Ажлын байраар хангахад зуучлах;

д\ Хоригдогчийн гэр бүлд чиглэсэн зөвлөгөө өгөх;

е\ Төрийн холбогдох байгууллага болон төрийн бус байгууллагуудтай хамтран цаашид бие даан амьдрахад нь зуучлах;

5.7.2. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтан нь хоригдогсдын дэглэмийн ялгааг харгалзан хорих ялын хугацаа дуусахаас 6 сарын өмнө нийгмийн амьдралд дасган хэвшүүлэх тусгайлсан төлөвлөгөөний хүрээнд арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

5.7.3. Ялын үндсэн хугацаа дуусч байгаа болон ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдах болзол хангасан хоригдогчийн иргэний бичиг баримтыг бүрдүүлэхэд эрх зүйн туслалцаа үзүүлнэ.

5.7.4. Нийгмийн ажилтан ажил олгогч, нийгмийн халамжийн байгууллагатай холбоо тогтоон, суллагдан гарах хоригдогчийг ажлын байртай болгоход зуучлах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.

5.7.5. Нийгмийн ажилтан хорих ангийн бусад алба, нийгмийн үйлчилгээний холбогдох байгууллагатай хамтран нийгмийн харилцаанд оролцох боломжийг нээхэд чиглэгдсэн ажлыг хэрэгжүүлнэ.

5.7.6. Нийгмийн үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх чиглэл бүхий дараах байгууллагуудтай хамтран ажиллана:

а/ нийгмийн даатгалын газар

б/ нийгмийн халамж үйлчилгээний газар,

в/ иргэний бүртгэлийн байгууллага,

г/ цагдаагийн байгууллага,

д/ хөдөлмөр зуучлалын төв,

е/ сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг байгууллагууд

ё/ төрийн бус байгууллагууд

5.7.7. Нөхөн сэргээх ажил нь хоригдогч суллагдсаны дараахь нийгмийн амьдралд хэвийн аж төрөх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгмийн харилцаанд зөв байр, суурьтай оролцоход чиглэгдэнэ.

Зургаа. Нийгмийн ажилтны аюулгүй байдлыг хангах ажиллагаа

6.1. Хоригдогчид мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, нийгэмшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах өрөө, тасалгаа нь нийгмийн ажилтны аюулгүй байдлыг хангахуйц буюу хяналт тавих боломжтой, тусгаарлах цонх, дохиолол, хяналтын камертай байна.

6.2. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд ажиллаж байгаа нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн /эмэгтэй/ мэргэжлийн үйл ажиллагаа явуулах өрөөг телекамержуулах болон бусад байдлыг хангах арга хэмжээг хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны удирдлагаас зохион байгуулна.

6.3. Нийгмийн ажилтан шаардлагатай үед аюулгүй байдлаа хангах арга хэмжээний талаар сургалтанд хамрагдаж зохих дадлага, ур чадвар эзэмшсэн байна.

Долоо. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны үйлчилгээг үнэлж, дүгнэх

7.1. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтнууд нийгмийн ажлын албанаас хийж гүйцэтгэсэн ажлын тайланг улирал тутам хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны удирдлагад тайлагнана.

7.2. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтнуудын үйл ажиллагааг дараахь үндсэн шалгуураар дүгнэнэ:

7.2.1. Нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүрэг, үр дүнгийн гэрээ, төлөвлөгөөний биелэлт; 7.2.3.

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгэмшүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалт буюу мэргэжлийн үйл ажиллагаанд гарсан өөрчлөлт үр дүн, хэмжих үзүүлэлт, хийсэн судалгаа, өгсөн үнэлэлт, дүгнэлт. 7.2.4. Хоригдогчийг нийгэмшүүлэх чиглэлээр

төрийн болон төрийн бус байгууллага, хоригдогчийн ар гэртэй ажилласан байдал, хамтран хэрэгжүүлсэн ажил, үр дүн,

7.2.5. Суллагдсан буюу суллагдах болзол хангасан хоригдогчид үзүүлсэн үйлчилгээ, шийдвэрлэгдсэн асуудал,

7.2.6. Мэргэжлийн байгууллагаас зохион байгуулсан хурал, сургалт, зөвлөгөөнд оролцсон болон өөрийгөө бие даан хөгжүүлсэн байдал, 7.2.7.

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд хоригдогчийг хүлээн авах, нийгмийн ажлын зөвлөгөө өгөх өрөө танхимын тохижилт, мэргэжлийн үйл ажиллагаандаа ашигласан байдал,

7.2.8. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны хэмжээнд хоригдогчид зориулан гаргасан мэдээ мэдээлэл, сурталчилгааны хуудас, гарын авлага, ном, түүний чанар үр дүн,

7.2.9. Хоригдогчийн өөрийгөө чадавхижуулах багийн үйл ажиллагааг зохион байгуулсан байдал, тэдний оролцоог хангаж, хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр. 7.2.10. Байгууллагын төлөв, дотоод үйл ажиллагаа, ажлын арга барилыг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмэр, санаачилсан хийсэн ажил, үр дүн.

7.2.11. Нийгмийн ажилтны үйл ажиллагаа буюу мэргэжлийн ур чадвар, хоригдогчтой ажилласан байдал, үйлчилгээний чанар, хоригдогчоос авсан санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байдал,

7.2.12. Нийгмийн ажилтны зүгээс хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны хоригдогчийг нийгэмшүүлэх ажлыг олон нийтэд сурталчлах талаар зохиосон ажил үр дүн.

7.3. Ялтны сургалт хүмүүжлийн хэлтсээс хагас, бүтэн жилийн эцэст бүсчилсэн хуваарийн дагуу хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны үйл ажиллагаатай биечлэн танилцах, үнэлгээ өгөх ажлыг зохион байгуулна.

Найм. Хүлээх хариуцлага

8.1. Энэ журмын 7 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу нийгмийн ажилтны үйл ажиллагааг хангалтгүй гэж үзвэл хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны дарга саналаа холбогдох баримт бичгийн хамт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт ирүүлнэ.

8.2. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанаас нийгэмшүүлэх ажлын үр дүнгийн талаар ирүүлсэн санал, Ялтны сургалт, хүмүүжлийн хэлтсээс хийсэн дүгнэлтээр нийгмийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагааг хангалтгүй дүгнэгдвэл Төрийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, бусад хууль тогтоомжинд заасны дагуу хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

8.3. Энэ зааврын хэрэгжилтийн биелэлтийг хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны даргын болон байгууллагын үйл ажиллагааг дүгнэхэд харгалзан үзнэ.

--- оОо ---